



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/02/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260815 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага.....	11
3.5.3 Урьдчилгаа	12
3.5.4 Бараа материал	12
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.8 Өр төлбөр.....	14
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Харьяа байгууллагууд.....	18
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	19
4.2.3.Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
УАОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ШУТС	Шинжлэх ухаан, технологийн сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
УГЗ	Урьдчилж гарсан зардал
ТББ	Төрийн бус байгууллага



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26 42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ Д.ОДГЭРЭЛ
ТАНАА

2022.03.25 № 01/715
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 397.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, "тохиолдсон байх", "толилуулга", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,183,808.4	16,557,708.5
31	Мөнгөн хөрөнгө	176,227.6	45,098.1
33	Авлага	1,027,018.1	965,170.3
34	Урьдчилгаа	14,253,659.1	13,041,591.3
35	Бараа материал	1,726,903.6	2,505,848.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	49,146,318.1	47,466,936.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,146,318.1	47,466,936.8
39200	Биет хөрөнгө	25,191,380.4	23,838,263.7
39300	Биет бус хөрөнгө	23,954,937.7	23,628,673.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	66,330,126.5	64,024,645.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	362,644.4	508,623.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,225.2	232,203.9
41300	Өглөг	85,770.7	226,281.9
41400	Урьдчилж орсон орлого	454.5	5,922.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	276,419.2	276,419.2
42200	Урт хугацаат зээл	276,419.2	276,419.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	65,967,482.1	63,516,022.2
51	Засгийн газрын хувь оролцоо	65,967,482.1	63,516,022.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,305,846.9	35,590,320.6
51200	Хуримтлагдсан үр дүн	13,671,958.5	14,222,298.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,989,676.7	13,703,402.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	66,330,126.5	64,024,645.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,350,386.4	26,041,997.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,826,281.0	3,940,318.8
120	Нийтлэг татварын бус орлого	3,489,228.4	3,869,370.5
121	Тусламжийн орлого	337,052.6	70,948.2
122	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,524,105.4	22,101,678.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	32,197,898.8	26,641,280.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,197,898.8	26,641,280.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,043,433.0	25,964,501.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,141,705.8	10,722,367.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,322,318.4	1,391,413.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	747,370.7	714,952.1
2104	Хангамж, бараа материалын зардал	367,503.5	891,797.7
2105	Нормативт зардал	401,905.0	575,461.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	241,925.4	360,509.1
2107	Томилолт, зочны зардал	184,474.5	124,159.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,558,922.9	7,952,850.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,077,306.9	3,230,990.5
211	ХҮҮ	8,916.8	780.6
212	ТАТААС	-	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,145,549.0	675,998.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(6,847,512.4)	(599,283.1)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	130,561.2	234,986.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	279,898.2	215,422.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(6,996,849.5)	(579,719.6)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	73,037,486.7	-	73,037,486.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(69,586.8)	-	(69,586.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,967,900.0	-	72,967,900.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,568.4)	-	(3,568.4)
5	Тайлант үеийн үр дүн	(6,996,849.5)		(6,996,849.5)
6	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	65,967,482.1	-	65,967,482.1
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,015,699.4)		(2,015,699.4)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,951,782.7	-	63,951,782.7
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	157,477.3		157,477.3
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(13,518.2)	-	(13,518.2)
11	Тайлант үеийн үр дүн	(579,719.6)	-	(579,719.6)
12	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	63,516,022.2	-	63,516,022.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	24,161,907.0	23,536,191.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,385,867.0	1,333,912.4
120	Нийтлэг татварын бус орлого	2,385,467.0	1,332,337.4
122	Тусламжийн орлого	400.0	1,575.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,776,040.0	22,202,279.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,987,986.1	23,243,046.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,987,986.1	23,243,046.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,521,036.8	22,550,977.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,102,576.5	10,627,522.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,348,766.9	1,376,072.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	771,558.4	616,265.3
2104	Хангамж, бараа материалын зардал	411,936.2	513,732.3
2105	Нормативт зардал	493,559.2	805,339.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	267,470.9	347,473.6
2107	Томилолт, зочны зардал	181,820.4	127,448.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,462,957.7	7,810,881.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,480,390.5	326,241.2
211	ХҮҮ	8,916.8	780.6

212	ТАТААС	371.2	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,457,661.3	691,289.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	173,920.9	293,145.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	263,105.1	424,274.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	263,105.1	424,274.6
2200	Дотоод эх үүсвэрээр	263,105.1	424,274.6
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(263,105.1)	(424,274.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(89,184.3)	(131,129.4)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	265,411.8	176,227.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	176,227.6	45,098.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,202,745,400.00	14,065,277,649.21	137,467,750.79	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,202,745,400.00	14,065,277,649.21	137,467,750.79	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,848,726,700.00	13,716,368,732.30	132,357,967.70	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,916,940,900.00	6,874,884,820.86	42,056,079.14	99.4
210101	Үндсэн цалин	5,179,087,000.00	5,121,570,548.68	57,516,451.32	98.9
210102	Нэмэгдэл	1,525,587,500.00	1,277,982,088.47	247,605,411.53	83.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	211,266,400.00	475,332,183.71	(264,065,783.71)	225.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	933,542,200.00	911,262,984.75	22,279,215.25	97.6
210201	Тэтгэврийн даатгал	656,344,300.00	650,671,491.91	5,672,808.09	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	69,299,400.00	68,195,249.34	1,104,150.66	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	55,439,700.00	53,641,370.74	1,798,329.26	96.8
210204	Ажилгүйдлийн даатгал	13,859,800.00	12,577,809.83	1,281,990.17	90.8
210205	Эрүүл мэндийн даатгал	138,599,000.00	126,177,062.93	12,421,937.07	91.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	391,189,500.00	387,615,109.16	3,574,390.84	99.1
210301	Гэрэл, цахилгаан	115,289,900.00	139,353,081.43	(24,063,181.43)	120.9
210302	Түлш, халаалт	127,673,900.00	114,580,353.36	13,093,546.64	89.7
210303	Цэвэр, бохир ус	23,904,500.00	8,086,474.37	15,818,025.63	33.8
210304	Байрны түрээс	124,321,200.00	125,595,200.00	(1,274,000.00)	101.0
2104	Хангамж, бараа материалын зардал	61,505,900.00	60,572,129.10	933,770.90	98.5
210401	Бичиг хэрэг	5,587,300.00	6,424,433.00	(837,133.00)	115.0
210402	Тээвэр, шатахуун	7,522,500.00	5,774,800.00	1,747,700.00	76.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,687,600.00	21,928,622.10	5,758,977.90	79.2
210404	Ном, хэвлэл	16,599,400.00	15,768,150.00	831,250.00	95.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	457,100.00	977,950.00	(520,850.00)	213.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,652,000.00	9,698,174.00	(6,046,174.00)	265.6
2105	Нормативт зардал	3,551,700.00	3,353,900.00	197,800.00	94.4

**Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,551,700.00	3,353,900.00	197,800.00	94.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,760,000.00	25,674,555.00	85,445.00	99.7
210604	Урсгал засвар	25,760,000.000	25,674,555.00	85,445.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	3,010,000.0	3,004,000.00	6,000.00	99.8
210702	Дотоод албан томилолт	3,010,000.00	3,004,000.00	6,000.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,512,619,900.00	5,449,394,633.43	63,225,266.57	98.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,469,084,700.00	5,407,269,577.43	61,815,122.57	98.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,278,000.00	15,278,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	586,000.000	451,800.00	134,200.00	77.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,096,700.0	1,635,762.00	460,938.00	78.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	177,900.00	22,000.00	155,900.00	12.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,477,400.00	16,325,525.00	151,875.00	99.1
210807	Газрын төлбөр	8,869,200.00	8,391,969.00	477,231.00	94.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	20,000.00	30,000.00	40.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	606,600.00	606,600.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	606,600.0	606,600.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	354,018,700.00	348,908,916.91	5,109,783.09	98.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	354,018,700.00	348,908,916.91	5,109,783.09	98.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	345,439,900.00	340,742,416.91	4,697,483.09	98.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,578,800.00	8,166,500.00	412,300.00	95.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,202,745,400.00	14,065,277,649.21	137,467,750.79	99.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,202,745,400.00	14,044,302,649.21	158,442,750.79	98.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	14,202,745,400.00	14,044,302,649.21	158,442,750.79	98.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	20,975,000.00	(20,975,000.00)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	75,000.00	(75,000.00)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	20,900,000.00	(20,900,000.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,020	1,020		100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	505	505		100.0
620001	Удирдах ажилтан	10	10		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	427	424	3	
620003	Үйлчлэх ажилтан	68	71	3	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	505	505		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	413	412	2	

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	92	93	1	
--------	--	----	----	---	--

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,297,438,167.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,281,856,097.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,105,893,368.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,389,688,146.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		178,973,266.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		6,193,689.50
2104	Хангамж, бараа материалын зардал		353,088,790.66
2105	Нормативд зардал		252,168,251.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		411,312,948.56
2107	Томилолт, зочны зардал		97,229,133.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,383,145,076.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		34,094,065.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		175,962,729.10
2132	Бусад урсгал шилжүүлэг		145,608,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		144,408,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		30,354,729.10
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		30,354,729.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		15,582,070.00
2200	Дотоод эх үүсвэрээр		15,582,070.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		15,582,070.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5,297,438,167.23
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,297,438,167.23
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		677,778,563.13
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,601,752,763.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,017,906,841.10
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад хэрэгжүүлж дууссан төсөл, хөтөлбөрийн үр дүнг төслийн гэрээнд заасан хугацаанд үр дүнг үнэлж дүгнэж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хооронд ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитор Ж.Энхтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 2/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааны зорилго нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон инновацын төсөл, арга хэмжээг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус сан нь Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх, Засгийн газрын /улсын/ захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхэд тэтгэлэг олгох, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, инновацын төсөл хэрэгжүүлэх, гарааны санхүүгийн дэмжлэг олгох, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх, шинжлэх ухаан, инновацын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол
- ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдан, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөнд нэр бүхий 13 байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийн ашиглалт, бүртгэлд хяналт шинжилгээ хийхээр тусгажээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/379 дугаар тушаалын дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн урсгал санхүүжилтийн дансанд хийсэн шалгалтаар илэрсэн 233.8 сая төгрөгийн 7 зөрчилд 6 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 88.0 хувьтай гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 26,856.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 268.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тодорхойлох шаардлагагүй гэж үзлээ

3.5 Санхүүгийн нэгтгэсэнтайлангийн тодруулга

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,305.5 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын сан данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 45.1 сая төгрөг болж, 131.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	176,277.6	42,747.0	(133,480.5)
Банканд байгаа бэлэн мөнгө		2,351.1	2,351.1
Дүн	176,277.6	45,098.1	(131,179.5)

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 45.1 сая төгрөг нь Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ТӨҮГ-ын харилцах дансанд 0.1 сая төгрөг, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн харилцах дансанд 2.3 сая төгрөг, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн арилжааны банкны харилцах дансанд 42.7 сая төгрөгийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: Нийт 208.6 сая төгрөгийн худалдан авалт цахим анхан шатны баримтаар нотлогдоогүй (Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 167.6 сая, Цөмийн физикийн судалгааны төв 3.7 сая, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 1.3 сая, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 35.8 сая төгрөг);

Бэлэн мөнгөний анхан шатны баримтад гарын үсгийн бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэсэн. (Шинжлэх ухаан, технологийн сан 3.4 сая, Цөмийн физикийн судалгааны төв 0.5 сая төгрөг);

Анхан шатны баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй (Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 21.2 сая төгрөг);

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 965.2 сая төгрөг болж, 61.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	14,383.9	18,277.8	3,893.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	401,660.4	703,654.5	301,994.0
Татаас, санхүүжилтийн авлага	312,169.8	19,066.0	(293,103.8)
АВЛАГА	298,803.8	224,172.0	(74,631.8)
Байгууллагаас авах авлага	248,218.8	183,939.9	(64,278.9)
Хувь хүмүүсээс авах авлага	50,585.1	40,232.2	(10,352.8)
Бусад авлага			
Дүн	1,027,018.1	965,170.3	(61,847.8)

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 965.2 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн сангаас 2002-2012 онд Зэхэц ажлын санхүүжилтэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн авлагыг БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 101/ШШ2020/02495, 2020 оны 101/ШШ2020/03410 дугаар шийдвэрээр 41.8 сая төгрөгийг барагдуулж улсын төсөвт төвлөрүүлсэн.
- Шүүхийн шийдвэрлэх шатанд 1 төслийн 52.4 сая төгрөг авлагыг шийдвэрлэх шатанд, эрэн сурвалжилж байгаа 7 төслийн хэрэгжүүлэгчтэй холбоотой 233.5 сая төгрөг;
- Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 2016-2019 онд үүссэн хүнсний ногоо, суулгац, материал, шатахуун, цалингийн тооцоотой холбоотой байгууллагаас авах 22.8 сая, хувь хүнээс авах 18.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага;
- Уламжлалт анагаах ухааны хүрээлэнгийн 2014 оноос өмнө үүссэн эзэн холбогдогч нь гадаадад байгаа 0.3 сая төгрөг, арбитрын шүүхийн шийдвэртэй эмийн тооцооноос үүссэн Новая Азия ХХК-аас авах 38.6 сая төгрөг, эмийн авлага 9.5 сая төгрөг;

- Уул уурхайн хүрээлэн ТЭЗҮ хийх гэрээний үүргээ биелүүлээгүйгээс Амгуулин ХХК-аас авах 14.0 сая төгрөг;

Эдгээр нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хууль журам хэрэгжихгүйгээс авлагын насжилт нэмэгдэх, найдваргүй авлага өсөх үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт: Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. (Цөмийн физикийн судалгааны төв 24.1 сая, Ургамал, газар тариалангийн хүрээлэн 7.3 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 139.9 сая төгрөг);

Авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй (Мал эмнэлгийн хүрээлэн 0.2 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 1.0 сая төгрөг);

Авлагын дансыг зардалд шууд хаасан (Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн 3.3 сая төгрөг) Өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй авлага, урьдчилгаа дансны үлдэгдэл хаагаагүй (Уул уурхайн хүрээлэн)

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 13,041.6 сая төгрөг болж, 1,212.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	14,222,145.3	13,039,789.6	(1,182,355.7)
Урьдчилгаа тооцоо	31,513.7	1,801.6	(29,712.1)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	12,501.8	1,801.6	(10,700.2)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	19,011.9	0.0	(19,011.9)
Дүн	14,253,659.1	13,041,591.2	(1,212,067.8)

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд төслийн санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөр 13,041.6 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнд:

- ШУТС-ийн санхүүгийн тайланд 2015-2021 онд иргэн, ААН, ТББ, ХХК, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад олгосон 577 төслийн санхүүжилт 11,922.0 сая төгрөг;
- Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн төслийн урьдчилж гарсан зардал 317.0 сая төгрөг;
- Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төслийн урьдчилж гарсан зардал 476.0 сая төгрөг;
- Уул уурхайн хүрээлэнгийн төслийн урьдчилж гарсан зардал 47.2 сая төгрөг
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн төслийн урьдчилж гарсан зардал 84.8 сая төгрөг

Төслийн хугацаа дуусаж санхүүжүүлэгч, захиалагчид төслийн үр дүн, санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй 127 төслийн 4,598.9 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэл байгаа нь хууль, журам хэрэгжихгүй байх, төсөл үр дүнгүй байх, төслийн зарцуулалтад тавих хяналт сул, санхүүгийн тайланд олон жилийн насжилттай зардал хуримтлагдах үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант онд урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй байгаа 127 төслийн үр дүнг хэлэлцээгүй байна. (Шинжлэх ухаан, технологийн сан 4,598.9 сая төгрөг), Урьдчилж гарсан зардал дансыг хасах тэмдэгтэй тайлагнасан (Цөмийн физикийн судалгааны төв 29.6 сая төгрөг) Урьдчилж гарсан зардал дансыг зардалд шууд хааж, дансны бичилт буруу хийсэн. (Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн 14.6 сая төгрөг, Мал эмнэлгийн хүрээлэн 70.9 сая төгрөг)

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл 2,505.8 сая төгрөг болж 778.9 сая төгрөг төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	234,377.2	425,105.7	190,728.5
Тусгай зориулалттай материал	177,023.4	338,014.9	160,991.5
Эм боох материал	57,353.7	87,090.8	29,737.0
Дуусаагүй үйлдвэрлэл	3,863.8	19,031.7	15,167.8
Бэлэн бүтээгдэхүүн	360,867.9	774,231.1	413,363.2
Хангамжийн материал	820,591.3	936,837.8	116,246.5
Бичиг хэргийн материал	119,930.0	176,595.3	56,665.2
Аж ахуйн материал	238,550.3	303,964.1	65,413.8
Сэлбэг хэрэгсэл	28,620.0	15,440.7	(13,179.4)
Түлш, шатах тослох материал	11,275.6	12,077.7	802.0
Барилгын засварын материал	40,647.9	33,397.3	(7,250.6)
Хүнсний материал	21,387.6	6,060.1	(15,327.6)
Бусад хангамжийн материал	360,179.6	389,302.7	29,123.1
Мал амьтад	307,203.3	350,642.5	43,439.1
Дүн	1,726,903.6	2,505,848.8	778,945.2

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал данс 778.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн болон өөрийн хөрөнгөөр 3,267.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, гадаад дотоодын хандиваар 579.2 сая, , шилжүүлэн авсан 700.2 сая, Дорнод салбарт тариалсан улаан буудайн үрийн нөөц бэлтгэсэн 52.2 сая, бусад эх үүсвэрээс 235.5 сая нийт 4,693.7 сая төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант хугацаанд зарцуулсан 3,394.4 сая, данс хооронд шилжүүлсэн 520.3 сая төгрөг нийт 3,914.8 сая төгрөгөөр хасагдсанаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт: Ашиглаж байгаа бараа материалыг зардалд бүртгэсэн, тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийг дутуу тайлагнасан, шатахууны орлого, зарлагыг бөөн дүнгээр бүртгэсэн, шатахуун зарцуулалтын жишиг нормыг илүү тооцсон, бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа номыг үндсэн хөрөнгийн дансанд давхар бүртгэсэн, худалдан авсан санхүүгийн онлайн программыг салбар хүрээлэнгүүдэд шилжүүлээгүй, бараа материалын дансанд бүртгэлтэй байхад хүрээлэнгүүдийн нягтлан бодогчид ашиглаж байна. (Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн 1.6 сая, Мал эмнэлгийн хүрээлэн 27.9 сая, Уламжлалт ангаах ухаан, технологийн хүрээлэн 40.5 сая, Цөмийн физикийн судалгааны төв 18.2 сая, Анагаах ухааны хүрээлэн 5.4 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 2.7 сая, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 7.3 сая, Шинжлэх ухаан, технологийн сан 15.1 сая төгрөг)

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 47,466.9 сая төгрөг болж, 1,679.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	16,800,501.2	15,977,813.0	(822,688.2)
Авто-тээврийн хэрэгсэл	1,145,059.9	1,009,903.1	(135,156.8)
Машин, тоног төхөөрөмж	5,895,770.9	5,643,089.1	(252,681.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	410,995.4	514,016.5	103,021.1
Зам, гүүрийн байгууламж	11,408.8	0	(11,408.8)
Бусад үндсэн хөрөнгө	714,929.4	478,382.5	(236,546.9)
Ном	212,714.9	215,059.3	2,344.4
Биет хөрөнгө	25,191,380.5	23,838,263.5	(1,353,117.0)
Программ хангамж	64,784.8	39,837.5	(24,947.3)
Бусад биет бус хөрөнгө	23,890,152.9	23,588,835.6	(301,317.3)
Биет бус хөрөнгө	23,954,937.7	23,628,673.1	(326,264.6)
Дүн	49,146,318.2	47,466,936.6	(1,679,381.6)

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс 1,679.4 сая төгрөгөөр буурсан нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн тайлан 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байсан боловч 2021 оноос Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага болж хөрөнгө нь шилжсэнээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 504 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан технологийн сангийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглагдах 148 нэрийн нийт 114,8 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж нийт 65.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1883 дугаар тогтоолын дагуу Шинжлэх ухаан, технологийн сан 18.1 сая, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 10.6 сая, Ургамал, газар тариалангийн хүрээлэн 13.5 сая, Цөмийн физикийн судалгааны төв 6.9 сая, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн 1.5 сая, Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн 21.9 сая, Мал эмнэлгийн хүрээлэн 63.6 сая, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 0.2 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 11.5 сая, нийт 148.1 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг данс бүртгэлээс хассан.

ТӨБЗГ-ын 2021 оны 623 дугаар тогтоолоор Ургамал, газар тариалангийн хүрээлэн 5.7 сая, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн 6.3 сая, Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн 3.0 сая, Мал эмнэлгийн хүрээлэн 72.4 сая, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 27.2 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 1.4 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Архангай аймаг дахь салбар 2.5 сая, нийт 118.6 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн асуудлыг ТӨБЗГ-т хандаж, холбогдох шийдвэрийг гаргуулаагүй. (Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн 78 ширхэг 763.5 сая төгрөг, Мал эмнэлгийн хүрээлэн 273 ширхэг 1,684.3 сая төгрөг, Анагаах ухааны хүрээлэн 136 ширхэг 336.6 сая төгрөг, Уул уурхайн хүрээлэн 194.1 сая төгрөг, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 412 ширхэг 1.3 сая төгрөг, Цөмийн физикийн судалгааны төв 10 ширхэг 7.3 сая төгрөг);

Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй тайлагнасан. (Цөмийн физикийн судалгааны төв 5 нэр төрлийн 7.2 сая, УГТХ-ийн Агроэкологийн бизнесийн сургууль 81.7 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 40 нэр төрлийн 32.0 сая төгрөг), Үндсэн хөрөнгөнд бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн, НБББББ-т заасан үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг баримтлаагүй, 1 жилээр тооцоноос үндсэн хөрөнгийг үлдэх өртөггүй тайлагнасан.(Цөмийн физикийн судалгааны төв 33.1 сая төгрөг)

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 508.6 сая төгрөг болж, 145.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	86,225.1	232,203.9	145,978.8
Ажилчидтай холбогдсон өглөг	19,812.0	92,088.1	72,276.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	8,295.6	93,238.5	84,942.9
Бусад өглөг	57,662.9	40,955.3	(16,707.6)
Байгууллагад төлөх өглөг	47,001.5	40,506.4	(6,495.1)
Хувь хүмүүст төлөх өглөг	10,661.4	448.9	(10,212.5)
Урьдчилж орсон орлого	454.6	5,922.0	5,467.5

Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	454.6	5,922.0	5,467.4
Урт хугацаат өр төлбөр	276,419.2	276,419.2	0.0
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	276,419.2	276,419.2	0.0
Нийт дүн	362,644.3	508,623.1	145,978.8

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 508.6 сая төгрөгөөс байгаагаас Мал эмнэлгийн хүрээлэнгийн цахилгаан, цэвэр, бохир усны өглөг 34.1 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тогтмол зардлын өглөг 34.7 сая, Мал хамгаалах санд өгөх өглөг 12.0 сая, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн тогтмол зардлын өглөг 7.4 сая, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт дутуу орж ирснээс Ази фарм ХХК-д эмийн өглөг 5.1 сая, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн ажилтнуудад өгөх 2021 оны 10, 11, 12 дугаар сарын цалингийн өглөг 26.6 сая, НДШ-ийн 34.2 сая, ХХОАТ-ын 10.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

Мөн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Дорнод салбар ХХААХҮЯ-ны харьяа ХААДС-аас авсан жимсний суулгац, үржүүлгийн далан байгуулах төслийн урт хугацаат зээл 107.5 сая, хүлэмжийн тоног төхөөрөмжийн урт хугацаат зээл 5.8 сая, нийт 113.3 сая төгрөгийн өр төлбөр ХААДС-ийн санхүүгийн тайланд бүртгэлгүйгээс тооцоо нийлэх боломжгүй, зээлээр авсан тоног төхөөрөмж данс бүртгэлд байхгүй, шүүхийн маргаантай гэх шалтгаанаар хугацаа хэтэрсэн.

Аудитын илрүүлэлт: Санхүүгийн тайланд бусад өглөгийг хасах тэмдэгтэй тайлагнасан, ХХОАТ-ыг дутуу тайлагнасан, НДШ-ийн өглөгийг илүү тайлагнасан. (Цөмийн физикийн судалгааны төв 12.7 сая, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн 5.5 сая төгрөг)

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 63,516.0 сая төгрөг болж, 2,451.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	38,305,846.8	35,590,320.6	(2,715,526.2)
Засгийн газрын оруулсан капитал	38,305,846.8	35,590,320.6	(2,715,526.2)
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
Хуримтлагдсан үр дүн	13,671,958.5	14,222,298.7	550,340.2
Өмнөх үеийн үр дүн	20,668,808.0	14,802,018.4	(5,866,789.6)
Тайлант үеийн үр дүн	(6,996,849.4)	(579,719.6)	6,417,129.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,989,676.7	13,703,402.8	(286,273.8)
Дүн	65,967,482.1	63,516,022.2	(2,451,459.9)

Эх сурвалж: ШУТС-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 35,590.3 сая төгрөг болж 2,715.5 сая төгрөгөөр буурсан нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн тайлан 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орж нэгтгэгдэж байсан боловч 2021 оноос Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага болж шилжсэн учраас Засгийн газрын хувь оролцоо данс 1,824.8 сая төгрөгөөр, тайлант оны үр дүн 579.7 сая төгрөгөөр тус тус буурахад голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд Анагаах ухааны хүрээлэн тайлант онд хөрөнгө акталж устгаснаас үүссэн 206.6 сая төгрөгийн дахин үнэлгээний зөрүүг бүртгэж, тайлагнасан байна

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,500.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,202.7 сая төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 297.3 сая төгрөгөөр бууруулан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,202.7 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 14,044.3 сая, үйл ажиллагааны орлогоос 20.9 сая, нийт 14,065.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна.

Хүснэгт 9. Үйл ажиллагааны орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	0	75.0	(75.0)	
Туслах үйл ажиллагааны орлого	0	20,900.0	(20,900.0)	
Нийт дүн	0	20,975.0	(20,975.0)	

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,065.3 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 42.1 сая, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 22.3 сая, байр ашиглалттай холбоотой зардал 3.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 63.2 сая төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-10 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	71805	Шинжлэх ухаан, технологи	14,202,745.4	14,065,277.6	137,467.7	99
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	8,335,500.2	8,266,367.5	69,132.7	99
1.2	80215	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	5,513,226.5	5,450,001.2	63,225.2	99
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	354,018.7	348,908.9	5,109.8	99

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бусад этгээдээс хандив тусламжаар 677.7 сая, дээд шатны төсөв захирагчаас 1,601.7 сая, төсвийн байгууллагын нэмэлт орлого 3,017.9 сая,

нийт 5,297.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 5,281.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 30.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 4 үзүүлэлтийн зорилтот түвшинд 14,202.7 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 99.0 хувийн биелэлттэй байна.

Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 107 дугаар тогтоолыг хүчингүй болгосноор тус байгууллага дараа оноос төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан гаргахгүй, тусгай сангийн тайланг төсвийн шууд захирагчаар гаргахаар өөрчлөлт орсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Шинжлэх ухаан, технологийн сан нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 2015 онд батлагдсанаас хойш нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчилж сайжруулалт хийгээгүй байна. Мөн харьяа хүрээлэнгүүд нь БШУС-ын 2017 оны Бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллажээ.

Тайлант онд Онол арга зүй төрийн бус байгууллагаар үйл ажиллагааны онцлогт тохирох НБББББ боловсруулахад хууль, эрх зүй, бүртгэлийн стандартын хүрээнд чиглүүлэх сургалт явуулж, хяналт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шинжлэх ухаан, технологийн сангийн харьяа байгууллагуудын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 1,925 мэдээлэл байршуулахаас 1,409.1 сая төгрөгийн 93 мэдээллийг хугацаа хоцроож, 693.7 сая төгрөгийн 8 мэдээллийг мэдээлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 1,564.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 1,298.2 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 227.3 төгрөгийн зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцуулах 4 албан шаардлага хүргүүлж, 39.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 10 төлбөрийн акт, 12 албан шаардлага, 38 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 99.4 хувьтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	10	38.8	10	38.8			100.0
Албан шаардлага	12	347.1	11	347.1	1	0	99.0
Зөвлөмж	38	2,071.4	37	2,057.4	1	14.0	99.3
Нийт дүн	60	2,457.3	58	2,443.3	2	14.0	99.4

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төслийн ажлын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд хяналт хийхэд цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудит хийх цар хүрээг хязгаарласан тул дараагийн аудитаар хугацаа дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч, санхүүжүүлэгчид төслийн болон санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй, гүйцэтгэл нь тодорхойгүй төслүүдэд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3,635.8 сая төгрөгийн 108 алдаа, зөрчил илэрснээс, 3,238.1 сая төгрөгийн 65 алдааг залруулж, 34.5 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 249.9 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 113.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 25 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 397.7 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 268.6 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 12 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэн, УГТХ-Агроэкологийн бизнесийн сургууль, Уул уурхайн хүрээлэн, Цөмийн физикийн судалгааны төв, Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнд “Зөрчилгүй”, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад нийт 2,148.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,750.5 сая төгрөгийн 47 алдааг аудитын явцад залруулж, 34.4 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 249.9 сая төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчил дахин давтан гаргахгүй байх 113.3 сая төгрөгийн 25 зөвлөмж өглөө.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын асуудлаар нийт 1,487.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,487.6 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас 1,487.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 23.0 сая, урьдчилгаа дансны үлдэгдэл 9.5 сая, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1.9 сая, хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 34.5 сая төгрөгөөр илүү, бараа материалын дансны үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр дутуу тус тус нэгтгэсэн;

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд татварын бус орлого 68.3 сая, санхүүжилтийн орлого 20.6 сая, бараа, ажил, үйлчилгээний зардал 52.8 сая, урсгал шилжүүлэг 1.4 сая, тайлант үеийн үр дүн 1,124.9 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнг 34.5 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн.

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд татварын бус орлого 60.4 сая, санхүүжилтийн орлого 20.6 сая, урсгал шилжүүлэг 1.4 сая, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 23.3 сая төгрөгөөр илүү, хөрөнгийн зардлыг 0.3 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;

Бараа материалын тодруулга тайлангийн нэмэгдсэн дүнг 1.6 сая төгрөгөөр илүү, хасагдсан дүнг 1.9 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн.

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэмэгдсэн дүнг 6.6 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн байна.

4.2.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсөл хөтөлбөртэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 4,598.9 сая төгрөгийн 127 төсөл, хөтөлбөрийн үр дүнг хэлэлцээгүй байна. Энэ нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.1.6."улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд нь хянан магадалгаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэх" заалтыг хэрэгжүүлээгүй.

1.2 Өгсөн зөвлөмж:

Хэрэгжүүлж дууссан төсөл, хөтөлбөрийн үр дүнг төслийн гэрээнд заасан хугацаанд дүгнэж, үр дүнг үнэлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Шинжлэх ухаан, технологийн сан (аппарат)	АХГ-2022/02/НА-СТА-ЗГТС	1				1	26	1,549,231.8	22	1,530,149.4	1	542	-	-	-	-	3	18,539.4	
2	Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн	АХГ-2022/69/НА-СТА-ТШЗ	1				1	7	30,015.0	4	27,629.0	-	-	-	-	-	-	3	2,386.0	
3	Мал эмнэлгийн хүрээлэн	АХГ-2022/63/НА-СТА-ТШЗ	1				1	8	129,783.2	2	99,932.0	1	1,768.2	-	-	-	-	5	28,083.0	
4	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61НА-СТА-ТШЗ	1	1				5	220,974.4	3	215,534.4	-	-	1	5,440.0	-	-	1	-	
5	Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/62НА-СТА-ТШЗ	1		1			17	523,924.5	6	228,516.7	5	25,952.0	2	220,182.8	-	-	4	49,274.0	
6	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	АХГ-2022/65НА-СТА-ТШЗ	1	1				8	856,757.6	7	856,757.6	-	-	1	-	-	-			
7	Уул уурхайн хүрээлэн	АХГ-2022/68НА-СТА-ТШЗ	1	1				4	2,193.6	-	-	-	-	1	-	-	-	3	2,193.6	
8	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/66НА-СТА-ТШЗ	1	1				3	6,750.0	2	1,790.0	-	-	1	4,960.0					
9	Ургамал газар тариалангийн хүрээлэн	ДАА-2022/138/НА-СА-ТШЗ	1	1				2	7,715.5	-	-	1	373.9	-	-	-	-	1	7,341.6	

**Шинжлэх ухаан, технологийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

10	УГТХ-Агроэкологийн бизнесийн сургууль	22/АО970289/ДАА-2022/139/ҮА-СА-ТШЗ	1	1				5	108,344.3	3	87,778.5	-	-	1	19,366.8	-	-	1	1,200.0
11	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70НА-СТА-ТШЗ	1	1				19	190,040.7	16	190,040.7	-	-	1	-	-	-	2	
12	Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	АХГ-2022/16/НА-СТА-ТӨА	1	1				4	10,131.4	-	-	2	5,849.9	-	-	-	-	2	4,281.5
	ДҮН		12	8	1		3	108	3,635,861.0	65	3,238,126.3	10	34,486.0	8	249,949.6	-	-	25	113,299.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар																			
1	Шинжлэх ухаан, технологийн сан (аппарат)	АХГ-2022/02/НА-СТА-ЗГТС						1	87.5					1	87.5				
2	Хөнгөн үйлдвэрлэл, судалгаа хөгжлийн хүрээлэн	АХГ-2022/69/НА-СТА-ТШЗ						1	15,325.5									1	15,325.5
3	Мал эмнэлгийн хүрээлэн	АХГ-2022/63/НА-СТА-ТШЗ						1	135,673.9					1	135,673.9				
4	Анагаах ухааны хүрээлэн	АХГ-2022/61НА-СТА-ТШЗ						1	200,383.50					1	200,383.5				
5	Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/62НА-СТА-ТШЗ						2	46,622.20					1		1	46,622.2		
6	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	АХГ-2022/65НА-СТА-ТШЗ						2	23,867.2-					1				1	23,867.2
7	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/66НА-СТА-ТШЗ						1	-					1					
8	Цөмийн физикийн судалгааны төв	АХГ-2022/70НА-СТА-ТШЗ						2	44,891.8					1		1	44,891.8		
9	Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	АХГ-2022/16/НА-СТА-ТӨА						1	642,164.50					1	642,164.5				
10	Ургамал газар тариалангийн хүрээлэн	ДАА-2022/138/НА-СА-ТШЗ						1	455,696.50					1	455,696.5				
	ДҮН							13	1,564,625.1	-	-	-	-	7	1,298,244.5	4	227,275.4	2	39,192.7
	Нийт дүн							121	5,200,486.1	65	3,238,126.3	10	34,486.0	15	1,548,194.1	4	227,275.4	27	152,491.8

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.